



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/300

Улаанбаатар хот

Зарим барилга байгууламжийг
нийслэлийн өмчид бүртгэн
авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 78 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж ашиглалтад орсон, нийт 390,168,209.00 (гурван зуун ерэн сая нэг зуун жаран найман мянга хоёр зуун ес) төгрөгийн өртөг бүхий, хавсралтад дурдсан барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авсугай.

2.Нийслэлийн өмчид шинээр бүртгэгдэж байгаа барилга байгууламжийг данс бүртгэлдээ бүртгэн авч, ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ (Т.Вандандорж)-т үүрэг болгосугай.


3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110201384



Нийслэлийн Засаг даргын 2024 оны
03 дугаар сарын 25-ны өдрийн
А/300 дугаар захирамжийн
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашиглалтад орсон он	Бүртгэх үнэ (төгрөгөөр)	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Бүртгэх байгууллага
1	Ус түгээх байр	Баянзүрх дүүргийн 28 дугаар хороо, Хужирбулангийн 5 хэсэг	2023	69,214,816.00	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө	"Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ
2	Ус түгээх байр	Сонгинохайрхан дүүргийн 33 дугаар хороо, Тахилтын 13-р гудамж	2023	101,309,594.00	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө	"Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ
3	Ус түгээх байр	Сонгинохайрхан дүүргийн 33 дугаар хороо, Тахилтын 4-р гудамж	2023	113,854,533.00	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө	"Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ
4	Ус түгээх байр	Сонгинохайрхан дүүргийн 33 дугаар хороо, Тахилтын 7-р гудамж	2023	105,789,266.00	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө	"Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ
Нийт дүн				390,168,209.00		